

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН  
2021 ОНЫ 04 ДҮГЭЭР САРД ХЭРЭГЖҮҮЛСЭН  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2021 оны 05 дугаар сарын 03

Улаанбаатар хот

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гадаадын иргэн, харьяатын газар нь Төрийн албаны тухай хууль, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай, Харьяатын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, Улсын онцгой комисс, Нийслэлийн онцгой комиссын шийдвэрийг баримтлан 2021 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 04 дүгээр сарын 30-ны өдрийг дуустал дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

НЭГ. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

1.1. Виз, зөвшөөрлийн чиглэлээр:

1.1.1. Гадаадын иргэнд үзүүлсэн хувийн урилга, виз, визийн зөвшөөрлийн үйлчилгээ:

Тайлант хугацаанд түр ирэгч, албан болон хувийн хэргээр оршин суухаар ирэх хүсэлт гаргасан төрийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, иргэний хүсэлтийг үндэслэн 567 гадаадын иргэнд визийн зөвшөөрөл олгосноос 466 иргэний визийн зөвшөөрлийг Монгол Улсаас гадаад улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газарт, 101 иргэний визийн зөвшөөрлийг хилийн боомтод тус тус илгээж, 166 гадаадын иргэнд зохих ангилал, зориулалтын Монгол Улсын визийг олгосон. */Хүснэгт 1/*

2021 оны дээрх тоон үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад визийн зөвшөөрөл олголт 72,7 хувиар, виз олголт 67,4 хувиар тус тус өссөн байна.

1.1.2. Гадаадын иргэний бүртгэл, хяналт:


Эрх бүхий байгууллагын зөвшөөрлийг үндэслэн 228 гадаадын иргэнд Монгол Улсад оршин суух зөвшөөрөл олгож, 568 иргэний оршин суух зөвшөөрлийн хугацааг сунган, оршин суух зөвшөөрөлтэй 199 иргэний бүртгэлд хасалт хийсэн. */Хүснэгт 1/*

Өндөржүүлсэн бэлэн байдал зарласантай холбогдуулан хөдөлмөр эрхлэгч, хөрөнгө оруулагч гадаадын иргэний Монгол Улсад оршин суух зөвшөөрлийн сунгалтыг цахим /e-visa.mn/-аар авч, тайлант хугацаанд нийт 76 аж ахуйн нэгж, байгууллагын 173 гадаадын иргэний хүсэлт ирснээс 50 аж ахуйн нэгж, байгууллагын 138 гадаадын иргэний хүсэлтийг, олон улсын хилийн боомтод 16 аж ахуйн нэгж, байгууллагын 24 гадаадын иргэний визийн зөвшөөрлийн хүсэлтийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу хянан шийдвэрлэж, 10 аж ахуйн нэгж, байгууллагын 11 гадаадын иргэний хүсэлтэд татгалзсан байна.

2021 оны дөрөвдүгээр сарын үзүүлэлтийг 2020 оны тухайн сарын үзүүлэлттэй харьцуулахад оршин суух зөвшөөрөл олголт 71,5 хувиар өсөж, харин оршин суух зөвшөөрлийн хасалт 38,2 хувиар буурчээ.

Мөн оршин суугаа хэлбэр нь өөрчлөгдсөн 11 гадаадын иргэнд визийн ангилал солих үйлчилгээ үзүүлж, уригч 12 аж ахуйн нэгж, иргэний хүсэлтийн дагуу гадаадын 12 иргэний виз, бүртгэлийн талаарх мэдээлэл бүхий тодорхойлолт олгосон байна.

Монгол Улсад түр хугацаагаар ирсэн 55 гадаадын иргэнийг бүртгэж, нутаг буцсан, статус өөрчлөгдсөн 54 иргэний бүртгэлд хасалт хийж, Монгол Улсад 90 хүртэл хоногийн визтэй ирсэн, мөн визгүй зорчдог түр ирэгч гадаадын иргэнээс тус улсад байх хугацааг сунгуулах хүсэлтийг хянан 24 иргэний визийн хугацааг 30 хүртэл хоногоор сунгаж, гадаадын 5 иргэнд регистрийн дугаар олгосон. */Хүснэгт 1/*



Монгол Улсад оршин суух цахим үнэмлэхийг 368 ширхэг шинээр хэвлэн, 453 үнэмлэхийн хүчинтэй хугацааг сунгаж, 40 үнэмлэхэд хаягийн хөдөлгөөний өөрчлөлт хийлээ.

1.2. Иргэний харьяаллын чиглэлээр:

1.2.1. Монгол Улсын харьяат болох, гарах, сэргээн тогтоолгох:

Монгол Улсын харьяат болох хүсэлт гаргасан гадаадын 6 иргэн /Бүгд Найрамдах Хятад Ард Улсын 6/-ний хүсэлт, баримт бичгийг шинээр хүлээн авч, мөн хүсэлт гаргасан гадаадын 5 иргэн /Бүгд Найрамдах Хятад Ард Улсын 5/-ний хүсэлтэд санал авахаар холбогдох байгууллагуудад, гадаадын 4 иргэн /Бүгд Найрамдах Хятад Ард Улсын 3, харьяалалгүй 1 хүн/-ний хүсэлтэд дүгнэлт үйлдэн Монгол Улсын Ерөнхий сайдад танилцуулахаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тус тус хүргүүлсэн.

Монгол Улсын харьяат болох хүсэлт гаргасан 1 иргэн /Бүгд Найрамдах Энэтхэг Улс/-ний хүсэлт, баримт бичиг Харьяатын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1-т заасан нөхцөлийг хангаагүй тул түдгэлзүүлсэн.

Гадаадын иргэн, харьяатын газрын даргын 2016 оны А/65 дугаар тушаалаар баталсан “Монгол Улсын харьяат болох хүсэлт гаргагчтай ярилцлага хийх журам”-ын дагуу хүсэлт гаргасан гадаадын 4 иргэн /Бүгд Найрамдах Хятад Ард Улсын 3, харьяалалгүй 1 хүн/-тэй 2021 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр ярилцлага хийсэн.


Монгол Улсын харьяатаас гарч бусад улсын харьяат болох хүсэлт гаргасан 3 иргэн /Бүгд Найрамдах Австри Улсын 1, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын 1, Япон Улсын харьяат болох хүсэлт гаргасан 1/-ний хүсэлт, баримт бичгийг шинээр хүлээн авч, Бүгд Найрамдах Казахстан Улсын харьяат болох хүсэлт гаргасан 1 иргэний хүсэлтийг хянан Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжлахаар Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлсэн.

Бүгд Найрамдах Казахстан Улсын харьяатаас гарч Монгол Улсын иргэний харьяаллаа сэргээн тогтоолгох хүсэлт гаргасан 4 харьяалалгүй хүний хүсэлтийг шинээр хүлээн авч, хүсэлт гаргасан 2 иргэний хүсэлтэд санал авахаар холбогдох байгууллагуудад, 2 харьяалалгүй хүний хүсэлтэд дүгнэлт үйлдэн Монгол Улсын Ерөнхий Сайдад танилцуулахаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.

Мөн Бүгд Найрамдах Солонгос Улсын харьяатаас гарч Монгол Улсын иргэний харьяаллаа сэргээн тогтоолгох хүсэлт гаргасан 2 харьяалалгүй хүний хүсэлтийг хянан, Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжлахаар Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлсэн.

Дээрх хугацаанд хоёрдмол харьяалал үүсгэсэн 3 иргэнийг шинээр бүртгэж, бүртгэлийг мэдээллийн санд оруулсан. /Хүснэгт 2/

Хүснэгт 2



Давхардсан тоогоор гадаадын иргэний нэгдсэн бүртгэлийн санд 51 улсын 3833 хоёрдмол харьяалалтай иргэн бүртгэлтэй байна.

1.2.2. Олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын бүртгэл, хяналт:

Олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацааг сунгуулах 4 байгууллагын хүсэлтийг хүлээн авсан.

2021 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар 87 төрийн бус байгууллага бүртгэлтэй байна.

1.3. Зөрчил шалган шийдвэрлэх чиглэлээр:


1.3.1. Гадаадын иргэнд тавих хяналт шалгалт:

Тайлант хугацаанд 1 удаагийн төлөвлөгөөт, 2 удаагийн төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг зохион байгуулж, нийт 6 аж ахуйн нэгж, байгууллага, гадаадын 47 иргэнийг хамруулснаас гадаадын 2 иргэнд Зөрчлийн тухай хуулийн дагуу 200,000 төгрөг /Хоёр зуун мянган/-ийн шийтгэл оногдуулж, улсын төсөвт төвлөрүүллээ.

1.3.2. Хориг арга хэмжээ:

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.11 дэх заалтыг үндэслэн 1 улсын 1 иргэн /Австралийн Холбооны Улсын 1/-ийг байгууллагын даргын 1 удаагийн тушаалаар албадан гаргасан. /Хүснэгт 3/

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 34 дүгээр зүйлд заасан үндэслэлээр 1 улсын 1 иргэн / Бүгд Найрамдах Хятад Ард Улсын 1/-ийг Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлж, 1 улсын 1 иргэн / Бүгд Найрамдах Хятад Ард Улсын 1/-ийг гарахыг түдгэлзүүлснийг хүчингүй болгож, хилээр нэвтрэх эрхийг сэргээн ажиллалаа. /Хүснэгт 3/



2021 оны дөрөвдүгээр сарын тоон үзүүлэлтийг 2020 оны мөн үетэй харьцуулахад зөрчил гаргасан гадаадын иргэн 88,9 хувиар, гарахыг түдгэлзүүлсэн гадаадын иргэн 85,7 хувиар тус тус буурч, зөрчил гаргасан уригч иргэн болон уригч хуулийн этгээд бүртгэгдээгүй байна.

### ХОЁР. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

2.1. Тогтоол шийдвэрийн хэрэгжилт, хүний нөөц, сургалт, олон нийттэй харилцах чиглэлээр:

2.1.1. Тогтоол шийдвэрийн хэрэгжилт, төлөвлөгөө, тайлан:

Засгийн газрын 100 хоногт хэрэгжүүлсэн ажлын тайланд тусгах тус байгууллагад хамаарах зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг 04 дүгээр сарын 26-ны өдрийн 01/613 дугаар, Монгол Улсын Засгийн газраас 100 хоногийн хугацаанд хэрэгжүүлэх ажлын 2021 оны төлөвлөгөөнд Хууль зүй, дотоод хэргийн яамнаас тусгасан арга хэмжээний хэрэгжилтийн явцыг 04 дүгээр сарын 05-ны өдөр цахимаар танилцуулж, 28-ны өдрийн 01/617 дугаар албан бичгээр тус тус Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

Мөн Засгийн газрын 100 хоногт хэрэгжүүлсэн ажлын тайланд тусгах тус байгууллагад хамаарах зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг 04 дүгээр сарын 26-ны өдрийн 01/614 дүгээр албан бичгээр Гадаад харилцааны яаманд хүргүүлэв.

Монгол Улсын Их Хурлын 2019 оны “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 18 дахь илтгэлийг хэрэгжүүлсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” 62 дугаар тогтоолын хэрэгжилтийг 04 дүгээр сарын 08-ны өдрийн 01/534 дугаар, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн тус байгууллагын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах зүйл, заалтын хэрэгжилтийн нэгдүгээр улирлын тайланг 04 дүгээр сарын 15-ны өдөр цахим хэлбэрээр, мөн 26-ны өдрийн 01/612 дугаар албан бичгээр тус тус Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүллээ.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг, даалгаврын нэгдүгээр улирлын хэрэгжилтийг үнэлгээ хийлгэн, 04 дүгээр сарын 07-ны өдрийн 01/519 дүгээр албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

Байгууллагын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөний төслийг боловсруулан 04 дүгээр сарын 08-ны өдрийн 01/535 дугаартай албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

Байгууллагын 2021 оны 03 дугаар сарын үйл ажиллагааны тайлан, 03 дугаар сарын төлөвлөгөөний хэрэгжилтийг тус тус 04 дүгээр сарын 05-ны өдөр тайлагнаж, 04 дүгээр сарын үйл ажиллагааны төлөвлөгөөг мөн өдөр баталлаа.

### 2.1.2. Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, хүний нөөц:

Тайлант хугацаанд төрийн захиргааны албан тушаалд 8, төрийн үйлчилгээний албан тушаалд 2 албан хаагч томилогдож, нэгж хооронд 3 албан хаагч шилжиж, 1 албан хаагч дэвшүүлэн томилогдсон, 4 албан хаагч чөлөөлөгдсөн байна.

Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчдын түр эзгүй байх хугацаанд албан ажлын зайлшгүй шаардлагаар тухайн албан тушаалын чиг үүргийн хэрэгжилтийг хариуцан, орлон ажиллах хуваарийг байгууллагын даргын А/76 дугаар тушаалаар баталж, төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчдын 2020 оны ажлын үр дүнгийн үнэлгээнд үндэслэн цалингийн шатлалыг ахиулах 89 албан хаагчийн цалинг 04 дүгээр сарын 19-ний өдрийн А/77 дугаар тушаалаар шинэчлэн тогтоолоо.

Улсын Онцгой комиссын шийдвэрийн хүрээнд цар тахлын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хорио цээрийн дэглэм, өндөржүүлсэн бэлэн байдлын “шар” болон “улбар шар” түвшинд хуваарийн дагуу ажиллах албан хаагчдын ажлын зохион байгуулалт, хариуцлага, сахилгыг дээшлүүлэх зохицуулалтыг тусгасан “Түр журам”-ыг А/72 дугаар, Улсын Онцгой комиссын 02 дугаар тогтоолын дагуу нийслэлд бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан 04 дүгээр сарын 25-ны өдрийг дуусталх хугацаанд ажлын байранд ажиллах албан хаагчдын хуваарийг байгууллагын даргын А/75 дугаар тушаалаар тус тус баталсан.

Гадаадын иргэн, харьяатын газраас авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, 03 дугаар сарын үйл ажиллагааны тайланг тус тус байгууллагын цахим хуудаст нээлттэй байршуулсан.

“Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангах зорилгоор “Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-г баталсан.

Үндэсний статистикийн хорооноос зохион байгуулсан төрийн албан хаагчийн Монгол үндэсний хэл бичгийн судалгаанд төвийн газрын албан хаагчдыг 04 дүгээр сарын 08-ны өдрөөс 12-ны өдрийн хугацаанд хамрууллаа.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн А/20 дугаар тушаалаар баталсан “Гадаадын иргэн, харьяатын газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц”-ийн хүрээнд тус агентлагт зарим бүтцийн нэгж нэмэгдсэн, өөрчлөн байгуулагдсантай холбогдуулан төрийн захиргааны удирдах албан тушаалын 1, гүйцэтгэх албан тушаалын 14 сул орон тоог “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-д заасны дагуу төрийн байгууллагад ажиллаж байгаа албан хаагчдаас болон удирдах албан тушаалтны нөөцөд байгаа иргэдээс нөхөх сонгон шалгаруулалтын товыг тогтоож, нийтэд зарлуулах хүсэлтийг салбар зөвлөлийн 04 дүгээр сарын 07-ны өдрийн 07 дугаар албан бичгээр хүргүүлэв.

“Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам”-ын дагуу төрийн албанд болон тухайн албан тушаалын ангилалд ажилласан жил, 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үнэлгээний багийн дүнг үндэслэн төрийн захиргааны 37 албан хаагчид дэс түшмэлийн зэрэг дэв шинээр болон ахиулан олгох саналыг 01/584 дугаар, 2 эрхэлсэн түшмэлийн зэрэг дэвийг ахиулах саналыг Төрийн албаны зөвлөлд салбар зөвлөлийн 08 дугаар албан бичгээр тус тус хүргүүлсэн.

### 2.1.3. Сургалт:

Удирдлагын академиас зохион байгуулсан Монгол улсын хөгжлийн бодлого: төлөвлөлт, хэрэгжилт, үнэлгээ “Алсын хараа 2050” сэдэвт богино хугацааны зайн сургалтад нэгжийн дарга нар болон захиргааны ахлах мэргэжилтнүүд нийт 20 албан хаагчийг, “Дархан-Энх Оршихуй” гадаад хэлний сургалтын төвтэй хамтран англи хэлний анхан болон дунд шатны цахим хичээлийг зохион байгуулж, төв болон орон нутгийн нийт 113 албан хаагчийг тус тус хамрууллаа.

Мөн зохион байгуулалтын нэгжийн орон тооны бус албан хэрэг хөтлөлт хариуцсан 9 албан хаагчийг хамруулсан архив албан хэрэг хөтлөлийн сургалтыг 3 хоногийн хугацаанд танхимаар зохион байгуулсан.

### 2.1.4. Олон нийт, мэдээ, мэдээлэл:

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээтэй холбоотой 11 мэдээ, мэдээллийг байгууллагын цахим хуудаст байршуулж, давхардсан тоогоор 33 хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлэв. Тухайлбал: Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбогдуулан байгууллагын дарга Н.Ууганбаярын өдөр тутмын “Өнөөдөр” сонинд өгсөн ярилцлага 04 дүгээр сарын 01-ний өдөр нийтлэгдсэн бөгөөд ярилцлагыг сонины эх сурвалжтайгаар [zaluu.com](http://zaluu.com), [zindaa.mn](http://zindaa.mn), [24tsag.mn](http://24tsag.mn), [eagle.mn](http://eagle.mn), [newspress.mn](http://newspress.mn) зэрэг 10 сайтад нийтлүүлэв. Мөн байгууллагын 20 жилийн ойн баярын өдрийг тохиолдуулан байгууллагын даргын мэндчилгээг олон нийтэд хүргэсэн.

Түүнчлэн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 12 мэдээлэл, коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх зөвлөмж, зөвлөгөө бүхий 5 зурагт хуудас, Монгол Улсын Засгийн газраас авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх 2 мэдээллийг байгууллагын цахим хуудаст байршууллаа.

### 2.2: Дотоод хяналт шалгалт, аюулгүй байдал, эрүүл мэндийн чиглэлээр:

#### 2.2.1. Дотоод хяналт шалгалт:

“Гадаадын иргэн, харьяатын газрын албан хаагчдын дүрэмт хувцас өмсөх, хэрэглэх журам”-ыг 04 дүгээр сарын 28-ны өдрийн А/82 дугаар, “Гадаадын иргэн, харьяатын газрын дотоод хяналт шалгалт зохион байгуулах журам”-ыг А/78 дугаар тушаалаар тус тус баталсан.

#### 2.2.2. Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрүүл аюулгүй байдал:

Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан Төв болон Агаарын замын боомт хариуцсан газрын ажлын байранд зайлшгүй ажиллах албан хаагчид, тэдгээрийн албаны болон хувийн автомашины судалгааг УОК-т цахим хэлбэрээр хүргүүлсэн.

04 дүгээр сарын 25-ны өдөр Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн эмч, эмнэлгийн ажилтны 11 хүний бүрэлдэхүүнтэй баг байгууллагад ажиллаж, вакцины 2 дугаар тунд төвийн 56 албан хаагч хамрагдлаа.

### 2.3. Хууль, эрх зүй, гадаад харилцааны чиглэлээр:

#### 2.3.1. Хууль, эрх зүй:

“Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллийг ашиглах, мэдээлэл нийлүүлэх, солилцох журам”-ын төсөлд саналаа тусган 04 дүгээр сарын 16-ны өдрийн 01/580 дугаар албан бичгээр Хууль зүй дотоод хэргийн яаманд хүргүүлэв.

Цахим гарын үсгийн тухай хуулийн төсөлд оруулах саналыг 04 дүгээр сарын 09-ний өдрийн 01/539 дүгээр, Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл, Сангийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлд саналыг 09-ний өдрийн 01/540 дүгээр, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын дагуу “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын төсөлд саналыг мөн 09-ний өдрийн 01/541 дүгээр албан бичгээр тус тус Хууль зүй дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

Шуудан хүргэлтийн KGB Tegbe компанитай хамтран ажиллах гэрээг баталлаа.

### 2.3.2. Гадаад харилцаа, хамтын ажиллагаа:

Бүгд Найрамдах Казахстан Улсын Элчин сайдын яамны Консулын хэлтсийн дарга Шынар Жуматаеватай танилцах уулзалтыг 03 дугаар сарын 30-ны өдөр, БНХАУ-ын Элчин сайдын яамны атташе, цагдаагийн хурандаа Заяатай хамтын ажиллагааны талаарх уулзалтыг 04 дүгээр сарын 07-ны өдөр тус тус зохион байгууллаа.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийг англи, хятад, орос, япон, солонгос хэлнээ албан бус хэлбэрээр орчуулан хянуулах хүсэлтээ 04 дүгээр сарын 23-ны өдрийн 1/606 дугаар албан бичгээр Гадаад харилцааны яаманд хүргүүлээд байна.

Мөн “Эрдэнэс Монгол” ХК-ын харьяа Эрдэнэс газр ХХК-ны дэд захирал Д.Ганхуяг болон “Гэрэгэ Системс ХХК”-ийн гүйцэтгэх захиралтай хамтын ажиллагааны талаар тус тус уулзалт зохион байгуулсан.

Ижил чиг үүргийн байгууллагуудын шинэ мэдээ, мэдээллийг “7 хоногийн тойм” нэрээр Хууль зүй, дотоод хэргийн яамны Олон улсын гэрээ, хамтын ажиллагааны газарт цахим хэлбэрээр хүргүүлэв.

### 2.4. Архив, албан хэрэг хөтлөлт, өргөдөл, гомдлын чиглэлээр:

#### 2.4.1. Архив, албан хэрэг хөтлөлт:

Тайлант хугацаанд 11 албан хаагчид 22 хадгаламжийн нэгж ашиглалтад олгож, 12 албан хаагчид 211 хуудас баримтыг “Хуулбар үнэн” тэмдгээр баталгаажуулж, хуулбарлан өгсөн.

2020 оны баримт бичгийг архивд хүлээн авах ажлын хүрээнд 2 нэгжийн 121 хадгаламжийн нэгжийг хүлээн авч, сан хөмрөгийн бүрдүүлэлт хийж ажиллав.

Байгууллагад ирүүлсэн нийт 135 албан бичиг /*хариутай 41, хариугүй 94*-ээс шийдвэрлэгдсэн 29, шийдвэрлэх шатандаа байгаа 12, байгууллагаас явуулсан 143 албан бичиг байна. Байгууллагын даргын баталсан 47 тушаал /*А тушаал 19, Б тушаал 28*-ыг бүртгэж, цахим хэлбэрт шилжүүлэн ажиллалаа.

#### 2.4.2. Өргөдөл, гомдлын чиглэлээр:

2021 оны гуравдугаар сард аж ахуйн нэгж, байгууллага, иргэн, албан хаагчдаас 20 өргөдөл ирүүлснийг хүлээн авч, 15 өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлэн, 5 өргөдөл шийдвэрлэлтийн шатанд хянагдаж байна. Хуулийн хугацаа хэтрүүлсэн өргөдөл байхгүй.

### 2.5. Мэдээллийн технологийн чиглэлээр:

#### 2.5.1: Программ хангамж:

Цахим хуудсын хөгжүүлэлтийн хүрээнд eVisa.gov.mn дээр визийн хүсэлтийг жагсаалтаар харах, хайлт хийх, хуудаслалт, дэлгэрэнгүй хэсэг, мөн шийдвэр гаргах хэсгийн frontend болон backend-ийн кодыг оруулсан бөгөөд нэг хэрэглэгч нэг регистрийн дугаараар хэд хэдэн хаяг үүсгэх боломжтой болгож нэмэлт хөгжүүлэлтийг хийв.

Төрийн мэдээлэл солилцооны ХУР, ДАН системийг ашиглах гэрээг шинэчлэн Үндэсний дата төв Улсын тооцоот үйлдвэрийн газарт хүргүүлсэн ба ХУР системээр дамжуулан 55 серверээр авч байгаа мэдээллийг ашиглах программ хангамжийг 04 дүгээр сарын 28-ны өдрөөс хэрэглэх боломжтой болгон хөгжүүллээ.

Виз, зөвшөөрлийн зааланд Гэрэгэ киоск төхөөрөмж суурилуулах, сүлжээ татах ажлыг зохион байгуулсан.

Тайлант хугацаанд зорчигчийн нэгдсэн мэдээллийн сан goTravel системийг Монгол Улсад нэвтрүүлэх НҮБ-ийн ажлын хэсэг, Гадаад улсуудтай вакцин хийлгэсэн хүмүүсийн мэдээллийг харилцан солилцох хил нэвтрэлтэд ашиглах ажлын хэсэг, e-mongolia.mn цахим хуудаст eVisa.mn цахим хуудсын 11 үйлчилгээг холбоосоор холбож ашиглах талаар ХХМТГ-тай хамтарсан цахим хуралд тус тус оролцлоо.

## 2.6. Санхүү, хөрөнгө оруулалт, хангамжийн чиглэлээр:

### 2.6.1. Төсвийн хөрөнгийн зарцуулалт:

2021 оны 04 дүгээр сард өссөн дүнгээр 1.210.3 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 912.4 сая төгрөгийг зориулалтын дагуу зарцуулж, холбогдох санхүүгийн баримт материалыг бүрдүүлэн, журналын бичилтийг тухай бүр бүртгэж ажиллалаа.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулахтай холбогдуулан төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны хөрөнгө оруулалтын төсвийн төслийн саналыг 2021 оны 01/622 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

Баян-Өлгий аймаг дахь хэлтсийн Цагаан нуур авто замын боомтын суурьшлын бүсэд албан хаагчдын амьдрах байр, Баруун бүс дэх газрын албаны байр барихад шаардагдах “Хөрөнгө оруулалт хүсэх тухай” 2021 оны 01/496, 01/497 дугаар албан бичгийг мөн Хууль зүй, дотоод хэргийн яаманд тус тус хүргүүлсэн.

### 2.6.2. Орлого төвлөрүүлэлт:

2021 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар Голомт банкны 1320000052 тоот дансанд өссөн дүнгээр 367.0 сая төгрөгийн улсын тэмдэгтийн хураамжийн орлого төвлөрүүлж, Хан-Уул дүүргийн татварын орлогын дансанд шилжүүлсэн.

Хан-Уул дүүргийн татварын орлогын дансанд 8.8 сая төгрөгийн хүү, торгуулийн орлого төвлөрүүлж, хяналтын улсын байцаагчдын шийтгэврийн хуудасны тайланг тулган баталгаажууллаа.

### 2.6.3. Хангалт, худалдан авалт:

Багаж тоног төхөөрөмж худалдан авах тендерт шалгарсан Монтех дистрибьюшн ХХК, Мэдээлэл технологийн үйлчилгээний тендерт шалгарсан Лидер Вишн ХХК, Голден Хоул ХХК-тай бараа бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээг баталгаажуулав.



Түүнчлэн Үнэлгээний хорооны зөвлөмжийн дагуу “Батзүү” ХХК-тай нормын хувцас, “Билэг дизайн” ХХК-тай өвөл, хавар намрын гутал нийлүүлэх гэрээг тус тус байгууллаа.

#### 2.7. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын чиглэлээр:

Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудын хамтран хэрэгжүүлэх 2021 оны нэгдсэн төлөвлөгөөний дагуу холбогдох ажил, арга хэмжээний 04 дүгээр сарын биелэлтийг 23-ны өдөр Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албанд хүргүүлэв.

“Салбарын статистик мэдээллийн сан бүрдүүлэх, эрхлэн хөтлөх, ашиглах журам”-ын дагуу байгууллагын 04 дүгээр сарын үйл ажиллагааны статистик мэдээг 01/499 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт хүргүүллээ.

Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, аюулгүй байдал алдагдах эрсдэлийг үнэлэх ажлын хэсгийн эрсдэлийн үнэлгээний тайланг 04 дүгээр сарын 09/05 дугаар албан бичгээр хүргүүлэн ажиллалаа.

#### 2.8. Хилийн боомт, орон нутгийн чиглэлээр:

Тайлант хугацаанд шинэ коронавирусын халдварын дэгдэлттэй холбогдуулан гаргасан Улсын онгой комиссын шийдвэр болон Засгийн газрын 2020 оны 39, 102 дугаар тогтоолын дагуу Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улстай хиллэдэг хилийн зарим боомтууд ажиллаагүй.

Хөшигийн хөндий дэх Чингис хаан олон улсын нисэх буудлын нүүлгэн шилжүүлэх дэд ажлын хэсгийн хуралдаанд нэгжийн дарга, хяналтын улсын ахлах байцаагчид 2021 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр оролцсон байна.

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗАР